



ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ
САЙДЫН ТУШААЛ

2010 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Нөөц бүртгэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2010 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Дорнод аймгийн Тамсагийн сав газар дахь Тосон-Уул XIX талбайн Т19-24 блокын баталгаат зэрэглэлийн газрын тос, тосонд ууссан хийн нөөцийг 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тооцон газрын тосны баталгаат (proved) зэрэглэлийн геологийн нөөцийг 119.02 сая тн, үүнээс ашиглалтын анхдагч нөөцийг 13.67 сая тн; тосонд ууссан хийн нөөцийг 2589 сая м³, үүнээс олборлож болох хийн анхдагч нөөцийг 296 сая м³ –ээр, 2009 онд гүйцэтгэсэн хайгуул, олборлолтын ажлын үр дүнд тооцсон Т19-55, Т19-Х61-2, Т19-7-1 блокууд болон Т19-24 блокгийн Т19-20, Т19-22 дэд блокуудад магадтай (probable) зэрэглэлийн газрын тосны геологийн нөөцийг 74.54 сая тонноор, тосонд ууссан хийн нөөцийг 4692 сая м³-ээр, боломжит (possible) зэрэглэлийн газрын тосны геологийн нөөцийг 52.78 сая тонноор, тосонд ууссан хийн нөөцийг 2987 сая м³-ээр тус тус Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэхийг Ашигт малтмалын газар /Д.Батхуяг/-т даалгасугай.

Хоёр.Газрын тосны анхдагч нөөцөөс Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын хугацаанд олборлосон хэмжээг тооцож нөөцийн хөдөлгөөн хийхийг Газрын тосны газар /Д.Амарсайхан/, Ашигт малтмалын газар /Д.Батхуяг/-т даалгасугай.

Гурав.Магадтай болон боломжит зэрэглэлийн нөөц бүхий талбайд нэмэлт хайгуул, туршилтын ажил явуулж нөөцийг баталгаат зэрэглэлд шилжүүлэх арга хэмжээ авахыг Газрын тосны газар /Д.Амарсайхан/-т даалгасугай.

Дөрөв."Петрочайна Дачин Тамсаг" ХХК-д дараах зүйлсийг даалгасугай. Үүнд:

4.1."Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам"-ын 15 дугаар зүйлийн 1 дэх заалт, "Тосон-уул XIX гэрээт талбайн талаар "Монгол газрын тос" компани болон "Медалион Монгол Ойл" компанийн хооронд байгуулсан БХГ"-ний 5.4 дүгээр заалтын "б" хэсэг, 8.5 дугаар заалтын дагууТосон-уул газрын тосны ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийг 6 сарын хугацаанд боловсруулж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, ТЭЗҮ-д ашиглалтын үеийн тос өгөмжийг 20-оос доошгүй хувьд хүргэж, нөөцийг байгаль орчинд хор хөнөөлгүй, эдийн засгийн үр ашигтай олборлох арга замыг тусгаж, хэрэгжүүлэх.

FROM : MFE

FAX NO. : 11318169

2010.02.17 23:53 P2

4.2.Хайгуулын ажлын нэгдсэн үр дүнгийн тайланг Монгол Улсад ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн тайланд тавигдах шаардлагад нийцүүлэн 6 сарын хугацаанд бэлтгэж, Монголын стратегийн комиссын дүгнэлт гаргуулан, Газрын тосны газар болон Ашигт малтмалын газрын Геологийн мэдээллийн санд тус тус хүлээлгэн өгөх.

Тав.Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Түлшний бодлогын газар /А.Эрдэнэлүрөв/ болон Газрын тосны газар /Д.Амарсайхан/ тус тус даалгасугай.



САЙД Д.ЗОРИГТ